



Нэгдүгээр хэсэг. СОНГОХ ДААЛГАВАР

Санамж: Нэгдүгээр хэсэг нь 50 сонгох даалгавартай нийт 76 оноотой. Даалгавар тус бүр 5 сонгох хариулттай. Тэдгээрийн зөвхөн нэг зөв хариултыг сонгож хариултын хуудсанд будаж тэмдэглээрэй. **Хариултын хуудасны заавартай сайтар танилцаарай.** Амжилт хүсье

- Газарзүйн зургийг ажиглан ЗУ96⁰-ийн шугамыг дайран өнгөрч буй аймгуудыг сонгоно уу? /1 оноо/




- Хэнтий, Завхан
 - В. Говь-Алтай, Ховд
 - С. Дорнод, Хэнтий
 - Д. Завхан, Говь-Алтай
 - Е. Архангай, Хөвсгөл
- Атлантын далайн талбайн хэмжээ жил болгон нэмэгдэж байгаа нь тектоникийн хавтангуудын ямар хөдөлгөөний үр дүн бэ? /1 оноо/



- Энэтхэг Австрали-Еврази, ойртон нийлэх
- Энэтхэг Австрали-Африк, холдон салах
- Африк – Өмнөд Америк, холдон салах
- Еврази-Номхон далай, шилжин зөрөх
- Еврази-Хойд америк,ойртон нийлэх



3. Дараах үзүүлэлтүүдийн аль нь хөгжиж буй орны шинж вэ? /1 оноо/
 А. Нийгмийн дундаж давхаргын эзлэх хувь их В. Хүн амын өсөлт бага
 С. Үйлчилгээний салбар эрчимтэй хөгжсөн Д. Шинээр аж үйлдвэржиж буй
 Е. Шинжлэх ухаан, технологийн ололт өндөр
4. 2017 оны байдлаар Монгол улс дэлхийн 189 оронтой дипломат харилцаатай байна. Энэ нь даяаршлын ямар хэлбэр бэ? /1 оноо/
 А. Соёлын даяаршил В. Эдийн засгийн даяаршил С. Нийгмийн даяаршил
 D. Улс төрийн даяаршил E. Ардчиллын даяаршил
5. Аж үйлдвэрийн салбаруудыг анхдагч, хоёрдогч, гуравдагч, дөрөвдөгч гэсэн хэв шинжүүдэд ангилдаг. Гуравдагч аж үйлдвэрийн хэв шинжид хамаарахыг нь сонгоно уу /1 оноо/
 А. Үйлчилгээний салбарууд В. Боловсруулах үйлдвэр С. Хөдөө аж ахуй
 D. Судалгаа шинжилгээ E. Харилцаа холбоо
6. Жилийн турш халуун, хуурай агаар бүхий их даралтын мужууд орших бүслүүр аль нь вэ? /1 оноо/
 А. Экватор орчмын бүслүүр В. Дулаан бүслүүр С. Халуун бүслүүр
 D. Хүйтэн бүслүүр E. Сэрүүн бүслүүр
7. Монгол улс 150 тэрбум гаруй тн нүүрсний нөөцтэй, 300 гаруй орд илэрцтэй. Багануурын нүүрсний орд нь дунд төрмөлийн аль галавт үүссэн бэ? /1 оноо/
 А. Триас В. Карбон С. Юра D. Перм E. Цэрд
8. Янз бүрийн гадаргын ойлгох чадвар өөр өөр байдаг. Дараах өгөгдлүүдээс хамгийн бага альбедотойг нь сонгоно уу /1 оноо/
 А. Элс В. Шинэ цас С. Ой мод D. Зузаан үүл E. Цөл
9. Тухайн температур бүхий агаарын үнэмлэхүй чийгийн хэмжээг үнэмлэхүй чийгийн багтаамжид харьцуулж тооцоолохыг юу гэж нэрлэх вэ? /1 оноо/
 А. Үнэмлэхүй чийгийн багтаамж В. Харьцангуй чийг С. Шүүдэр цэг
 D. Дутмаг чийг E. Үнэмлэхүй чийг
10. Голын уналыг уртад нь харьцуулсан үзүүлэлтийг юу гэдэг вэ? /1 оноо/
 А. Голын хөндлөн зүсэлт В. Голын унал С. Голын хэвгий
 D. Голын дундаж гүн E. Голын сүлжээний нягтшил
11. Зурагт 10-ийн тоогоор тэмдэглэсэн урсгалыг нэрлэнэ үү? /1 оноо/



- А. Перугийн урсгал В. Гольфстримийн урсгал С. Баруун зүгийн салхины урсгал
 D. Бразилийн урсгал E. Канарын урсгал




12. Хөрсний доройтол, элэгдэлд нөлөөлөх БАЙГАЛИЙН хүчин зүйлийг сонгоно уу /1 оноо/

- A. Усалгаатай талбай нэмэгдэх
B. Шар усны үерт автах
C. Дэд бүтэц тэлэх
D. Аж үйлдвэржилт нэмэгдэх
E. Мал аж ахуй эрчимжих

13. Оросын Холбооны улс 143.000.000 хүн амтай, газар нутгийн хэмжээ 17.023.000 км² бол хүн амын нягтшил хэд байх вэ? /1 оноо/

- A. 1км²-т 8.4 хүн ноогдоно
B. 1км²-т 6.4 хүн ноогдоно
C. 1км²-т 4.4 хүн ноогдоно
D. 1км²-т 5.4 хүн ноогдоно
E. 1км²-т 7.4 хүн ноогдоно

14. Зургийг ажиглан растерийн оновчтой дүрслэлийг сонгоно уу /1 оноо/



A.

B.

C.

D.

E.

15. Цэгийн оронд тохирох үгийг сонгоно уу. Газарзүйн мэдээллийн систем нь компьютерт суурилсан буюу тоон.....орон зайн өгөгдлийг ашиглан газарзүйн зураг, газарзүйн мэдээллийн загварчлалыг боловсруулдаг технологийн шийдэл юм. /1 оноо/

- A. тандалт B. байршил C. өгөгдөл D. технологи E. зураглал

16. Дараах улсуудыг орших газартай нь зөв харгалзуулсан хариултыг сонгоно уу. /1 оноо/

Орших газар	Орших улсууд
1. Арал	а. Хойд Солонгос
2. Хойг	б. Австрали
3. Эх газар	в. Куба

- A. 1а, 2в, 3б B. 1б, 2в, 3а C. 1а, 2б, 3в D. 1б, 2а, 3в E. 1в, 2а, 3б

17. Даяаршлын СӨРӨГ талыг дурдсан хариултыг сонгоорой. /1 оноо/


- A. Улс дамнан зайнаас ажил хийх
B. Шинэ санаа, мэдээлэл солилцох
C. Цөөхөн улс орон улам хүчирхэгжих
D. Төвлөрлийг сааруулах
E. Технологийн ололт амжилт нэвтрэх



18. Зургийн агуулга юуг илэрхийлж байгааг хариултаас сонгоно уу /1 оноо/




24. Биомандлын хил хязгаарыг тогтоодог үндэслэл юу болохыг нэрлээрэй. /1 оноо/



- A. Үржил шим сайтай хөрсний тархалт
- B. Амьдрах нөхцөл, амьдралын ул мөр
- C. Органик гаралтай чулуулгийн тархалт
- D. Ашигт малтмалын тархалт байршил
- E. Ургамлын бүрхэвч тархалт ул мөр


25. 1800 оны эхэн хүртэл дэлхийн хүн амын тоо 1 тэрбумд хүрдэггүй байв. Графикийг ажиглан хэдэн оны хооронд хүн амын өсөлт хамгийн бага байгааг сонгоно уу /2 оноо/



- A. 1900-1950
- B. 1850-1900
- C. 1800-1850
- D. 1750-1800
- E. 1700-1750



26. Хүн амын суваргыг ажиглаарай. Хэдээс хэдэн насны эмэгтэйчүүдийн эзлэх хувь их байна вэ? /2 оноо/




- A. 30-34 насны
- B. 35-39 насны
- C. 25-29 насны
- D. 40-44 насны
- E. 5-9 насны

27. Цэгийн оронд тохирох үгийг нөхөөрэй.

Саудын Араб улсаас Япон улс руу жилд дунджаар 600 сая орчим тнтээвэрлэдэг. Үүний дийлэнх ньтээврийн төрлийг ашигладаг байна. /2 оноо/

- A. газрын тосыг, усан замын
- B. байгалийн хийг, хоолойн
- C. нүүрсийг, авто замын
- D. алтыг, дамжуулах хоолойн
- E. зэсийг, цахилгаан


28. Газар хөдлөлтийн хүч, хугацаа давтамжийг сейсмографийн тусламжтайгаар тогтоож болдог. Зургийг ажиглан хэддэх секундээс эхлэн чичирхийлэл тогтворжсоныг сонгоно уу. /2 оноо/



- A. 15 дахь секундээс
- B. 25 дахь секундээс
- C. 12 дахь секундээс
- D. 10 дахь секундээс
- E. 9 дахь секундээс



29. Зургийг ажиглан стратосфер /давхраат мандал/-ийн давхаргыг зөв тодорхойлсон хариултыг сонгоорой. /2 оноо/



- А. Ионжилт их, устөрөгч илүү зонхилно.
- В. Температур буурч, салхины хурд 150м/сек хүрнэ
- С. Цаг агаарын бүх үзэгдэл явагддаг.
- Д. Температур нэмэгдэж 1500°C хүрнэ.
- Е. Үүлгүй. Озоны давхарга оршино.


30. 2005 оны 8 сарын Катрина хар салхины үеэр 1836 хүн амь насаа алдан, 108 тэрбум ам/долларын хохирол учирчээ. Зургийг ажиглан хар салхины үргэлжилсэн өдрүүд болон даралтыг ажиглан салхины хүч суларсан өдрүүдийг сонгоно уу /2 оноо/



- А. 29-30-ны өдрүүд
- В. 24-25-ны өдрүүд
- С. 25-26-ны өдрүүд
- Д. 30-31-ны өдрүүд
- Е. 26-27-ны өдрүүд



31. Завхан аймгаас Оросын Холбооны улс руу явахад хамгийн ойрын, байнгын ажиллагаатай боомт аль нь вэ? /2 оноо/



- A. Алтанбулаг-Хиагт В. Боршоо-Хандгайт С. Бичигт-Зүүнхатавч
D. ЗамынҮүд-Эрэн Е. Гашуунсухайт-Ганц мод

32. Google earth программын зурагт 4-ийн тоогоор тэмдэглэсэн командыг идэвхжүүлээд цаг агаарын ямар элементийг харж болох вэ? /2 оноо/



- A. Салхи
B. Үүлшилт
C. Температур
D. Хур тунадас
E. Даралт

33. Доорх зургийг ашиглан Дэлхий ба Бархасбадь гаригуудын хоорондын зайг одон орны нэгжээр /о.о.н/ илэрхийлээрэй./1 о.о.н=Нар дэлхийн хоёрын хоорондох зай/ /2 оноо/



- A. 7.18 о.о.н B. 5.18 о.о.н C. 6.18 о.о.н D. 4.18 о.о.н E. 8.18 о.о.н



34. Нар, дэлхий, сар гэсэн дарааллаар нэг шулуун дээр давхцах үеийг юу гэж нэрлэх вэ? /2 оноо/
 А. Тал сар В. Сарны фаз С. Битүүн D. Нар хиртэлт E. Сар хиртэлт
35. Зургийг ажиглан 8 ба 6-ийн тоогоор тэмдэглэгдсэн хаант засаглалтай Европ тивийн улсыг сонгоно уу. /2 оноо/



А. Норвег, Испани
 D. Испани, Непал

В. Их Британи, Япон
 E. Ватикан, Япон

С. Тайланд, Бруней


36. Хүн амын ихэнх нь англи хэлтэй, протестант шашинтай, сагсан бөмбөг тоглож, рэйп хөгжим сонсож, түргэн хоолны газраар үйлчлүүлдэг бол соёлын газарзүйн тархалтын ямар мужид хамаарах вэ? /2 оноо/
 А. Зүүн өмнөд Ази В. Хойд америкийн С. Араб исламын
 D. Словян ба оросын E. Зүүн өмнөд азийн
37. Дараах хотуудаас ЕВРОП тивийн бета хотыг сонгоорой. /2 оноо/
 А. Лос-Анжелес В. Бостон С. Осака D. Мадрид E. Хонконг
38. Малчин Б-ынх 12 үхэр, 8 адуу, 20 ямаа, 55 хонь нийт 95 толгой малтай ба бэлчээрийн даацын хуваарилалт хийхийн тулд бүх сүргийг хонин толгойд шилжүүлэн тооцоолно уу. /1 үхэр=6 хонь, 1 адуу=6 хонь, 1 ямаа=0.9 хонь, 1 хонь=1 хонь/ /2 оноо/

- А. 193 хонин толгой
 В. 133 хонин толгой
 С. 173 хонин толгой
 D. 103 хонин толгой
 E. 182 хонин толгой

Бодолт:



39. Графикийг ажиглан интернетээр мэдээлэл авах хэрэгцээг хангах шаардлагатай орнуудыг сонгоно уу (*Worldwide Statista, 2020*) **/2 оноо/**



- А. Хятад, Япон В. Узбекистан, Киргизстан С. Канад, Аргентин
 D. Португал, Непал E. Герман, Турк

40. Жуулчид Хамрын хийд рүү аялалд гарахаар болжээ. Рекреацийн ямар нөөцөд тулгуурласан аялал болох вэ? **/2 оноо/**


- А. Цэнгэг уст нуур, цаатангуудын аж амьдрал
 В. Эмчилгээний болон рашаан сувилал
 С. Түүхэн хөшөө, хиргисүүр, гэрэлт хөшөө
 D. Хүний гараар бүтээгдсэн сүм хийд, музей
 E. Эргийн наран шарлага, амралтын газар

41. Тухайн бүсийн онцлогийг зөв тодорхойлсныг нь сонгоно уу. **/2 оноо/**



- А. Баруун өмнөд Ази - Газрын тосны олборлолт
 В. Зүүн өмнөд Ази-Тээвэр, шинэ аж үйлдвэржилт
 С. Баруун Европ-хотжилт, машин үйлдвэрлэл өндөр
 D. Зүүн Ази-Технологи, электроник
 E. Төв Америк -Хөдөө аж ахуй газар тариалан

42. Графикийг ажиглаарай. 7-р сард салхины хурд өмнөх оны мөн сараас хэдэн м/сек-ээр нэмэгдсэн байна вэ? /2 оноо/



- A. 1.0 м/сек
- B. 0.5 м/сек
- C. 1.5 м/сек
- D. 2.0 м/сек
- E. 2.5 м/сек


43. Австралийн эх газрын гадаргын байдлыг зөв тодорхойлсон хариултыг сонгоорой. /2 оноо/



- A. Өмнөд талаараа уулархаг, нуурууд ихтэй.
- B. Баруун талаараа өндөрлөг, гадаргын ус ихтэй
- C. Зүүн талаараа талархаг, нуурын тархалт ихтэй
- D. Төв хэсгээрээ гадаргын ус их, өндөр уулстай
- E. Зүүн талаараа уулархаг, баруун, баруун хойд талаараа цөлөрхөг



44. Тасалгааны температур $+10^0$ С байв. Үнэмлэхүй чийгийн хэмжээ 6.3 гр/м^3 бол харьцангуй чийгийн хэмжээ хэд байгааг тооцоолно уу /агаарын температур $+10^0\text{C}$ байх үед чийгийн багтаамж 9.41 гр/м^3 байна./ **/2 оноо/**
 A. 80.3% B. 66.9% C. 18.3% D. 30.3% E. 15.3%
45. Гамби улс дотоодын усны хэрэглээнийхээ 94%-ийг импортоор авдаг. Үүнд нөлөөлсөн байгалийн хүчин зүйлийг сонгоорой. **/2 оноо/**
 A. Далайн хүйтэн урсгалын нөлөө B. Хүн амын усны хэрэглээ өндөр
 C. Хөвөнгийн тариалалтад ус их хэрэглэнэ D. Дотоодын мөргөлдөөн зөрчил их
 E. Усны зохисгүй хэрэглээтэй
46. Хөдөө аж ахуйн салбарт хөрсний үзүүлэх үүрэг нь юу вэ? **/2 оноо/**
 A. Түүх соёлын өв тээгч болдог B. Гүний усны нөөцийг бүрдүүлдэггүй
 C. Агаарын температурт нөлөөлдөггүй D. Уур амьсгалыг тэнцвэржүүлдэггүй
 E. Хүнс тэжээл, үр тарианы эх үүсвэр болдог
47. Google earth-ийн зургийг ажиглан Алтай центр Улсын их дэлгүүрээс аль зүгт байгааг тодорхойлоорой. **/2 оноо/**



- A. Баруун B. Зүүн өмнөд C. Баруун өмнөд D. Зүүн E. Хойд
48. Тус улс нь 4.000.000 хүн амтай, хүн амын ердийн өсөлт нь 2% бол хэдээр нэмэгдсэнийг тооцоолоорой. **/2 оноо/**

- A. 2000
 B. 48000
 C. 20000
 D. 80000
 E. 40000

Бодолт:



49. Лондон хотын агаарын температур $+72^{\circ}\text{F}$, Бусан хотын агаарын температур $+18^{\circ}\text{C}$ байв. Хоёр хотын агаарын температурын зөрүү франгейтын хуваариар хэд болохыг тооцоолоорой. **/2 оноо/** $\frac{9}{5}^{\circ}\text{C} + 32 = ^{\circ}\text{F}$
- A. 54.4°F B. 84.4°F C. 15.2°F D. 7.6°F E. 10.6°F

50. Хүснэгтэн мэдээллийг ашиглан Монгол улсын эрчим хүчний усны хэрэглээ дэлхийн дунджаас хэдэн %-иар илүү байгаа шалтгааныг тодорхойлж тооцоолол хийнэ үү. **/2 оноо/**

№	Салбар	Дэлхийн дундаж/%/	Монгол улсын дундаж/%/
1	Хөдөө аж ахуй	67	28
2	Хүн амын унд, ахуй	9	16
3	Эрчим хүч	7	25
4	Үйлдвэрлэл	11	8
5	Уул уурхай	2	22
6	Бусад	4	1
Нийт		100	100


- A. Нарны эрчим хүч голлоно. Дэлхийн дунджаас 28%-иар бага
 B. Усан цахилгаан станц голлоно. Дэлхийн дунджаас 25%-иар их
 C. Дулааны цахилгаан станц голлоно. Дэлхийн дунджаас 18%-иар их
 D. Салхины эрчим хүч голлоно. Дэлхийн дунджаас 25%-иар бага
 E. Атомын эрчим хүч голлоно. Дэлхийн дунджаас 7%-иар их




2.2 Монгол улсын 2023-2024 оны нислэгийн тоон мэдээллийг ашиглан даалгавруудыг гүйцэтгээрэй. /6 оноо/

I. Улаанбаатараас хамгийн олон хүн зорчдог бета зэрэглэлийн хот аль нь вэ? **/a/**
/2 оноо/

1. Истанбул 2. Токио 3. Бээжин 4. Сөүл 5. Фукуока



II. Орон нутгийн нислэгийн графикийг ашиглан өмнөх оноос хэдэн хувиар өссөнийг тооцоолоорой. /bc.d/ /2 оноо/


[illegible]

III. Автобус 150 км-ын зайтай хоёр хотын хооронд 31 хүн тээвэрлэсэн бол зорчигч эргэлтийг олоорой. /efgh/ /2 оноо/

[illegible]

2.3 Гадаргыг өөрчилдөг эндоген ба экзоген хүчин зүйлстэй холбогдох даалгавруудыг гүйцэтгээрэй. /6 оноо/

I. Зургийг ажиглан Евразийн хавтанд хамаарагдах газар нутгийг нь сонгоно уу /a/ /1 оноо/



1. Атлантын далай, Гренланд арал
3. Атлантын далай, Японы арал
5. Карибын тэнгис, Панамын суваг

2. Атлантын далай, Мадагаскар арал
4. Энэтхэгийн далай, Тасман арал

II. Эндоген ба экзоген үйл явцуудыг зөв харгалзуулна уу. /5 оноо/ [b][c][d][e][f]

B	Номхон далайн хавтангийн хил заагаар орших галт уул, газар хөдлөлтийн бүсүүд	1	Антиклинал
C	Чулуулгийн ан цавд ус хөлдөж тэлснээс үүсэх өгөршил	2	Температурын өгөршил
D	Эрдэс чулуулаг, хоногийн температурын өөрчлөлтөөс хамаарч бутрах	3	Галт цагираг
E	Дээд мантийн дээд үед орших халуун хайлмал гулгамтгай үе	4	Хүйтний өгөршил
F	Гадаргын атирааны гүдгэр хэлбэр	5	Астеносфер

2.4 Хүснэгтэн мэдээллийг ашиглан дараах даалгавруудыг гүйцэтгээрэй. /6 оноо/

№	Далайн үзүүлэлтүүд	А. Номхон далай	Б. Атлантын далай	В. Хойд мөсөн далай	Г. Энэтхэгийн далай	Д. Өмнөд далай
1	Талбай /сая.км2/	165.2	92.4	14.0	73.5	15.9
2	Дундаж гүн /м/	4280	3646	1038	3741	4500
3	Температур /°C/	28.3	21.5	-1.2	25.2	2.5
4	Давсжилт /‰/	34.1	33.2	32.1	34.5	34.2

I. Далайн усны давсжилтыг илэрхийлэх хэмжигдэхүүнийг сонгоно уу. /a/ /1 оноо/

1. Франгейт
2. Паскаль
3. Метр/куб
4. Процент
5. Промиль

II. Атлантын далай ба Номхон далайн температурын дундажийг тооцоолоорой. /b.c.d/ /2 оноо/

III. Дундаж гүний тоон утгыг ихээс бага руу нь эрэмбэлээрэй. /e/ /3 оноо/

1. Д-Б-Г-А-В
2. Б-А-Г-Д-В
3. Д-А-Г-Б-В
4. Г-Б-А-Д-В
5. В-Б-Г-Д-А

